



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Онгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2025/136-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Онгон сум
2025 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Г.Даваа
Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn
Аудитын менежер: М.Нарантуяа
Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn
Аудитор: Б.Бүзмаа
Утас: 91160110 Цахим хаяг: Buzmaa@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Албан шаардлага	9
3.2 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2025.02.25 № 156

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2024 онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,142,294.1 мянган төгрөг, үүний 1,086,679.1 мянган төгрөгийн санхүүжилт улсын төсвөөс, 55,615.0 мянган төгрөгийн санхүүжилт орон нутгийн төсвөөс санхүүжихээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 86,606.7 мянган төгрөг 1,141,794.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, өөрийн орлогоор 610.0 мянган төгрөг төвлөрүүлсэн ба 1,037,662.6 мянган төгрөгийн урсгал зардал гарсан, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 191,348.3 мянган төгрөгийг тайланд толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлыг тодорхойлоход материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн үнэлгээ өндөр, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын шийдвэр гаргасан чухал асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал гараагүй болно.

Бусад асуудал

2024-2025 оны хичээлийн жилд 309 хүүхэд хамрагдахаас 305 хүүхэд хамрагдаж хамрагдалтын хувь 98.7 хувьтай байна.

Сүхбаатар аймгийн боловсролын газрын даргатай хийсэн 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 3 зорилтот хөтөлбөрийн 54 арга хэмжээний биелэлт 88.9 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Г. ДАВАА

51220	Тайлант үеийн үр дүн	83,984,144.11	107,588,289.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	69,763,266.42	69,763,266.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	447,238,491.73	551,252,030.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	809,630,011.00	1,169,908,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,399,311.00	28,114,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	36,399,311.00	28,114,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,220,600.00	28,114,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	610,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,220,600.00	27,504,400.00
120009	Бусад орлого	1,178,711.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	773,230,700.00	1,141,794,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	743,586,500.00	1,086,679,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	743,586,500.00	1,086,679,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,644,200.00	55,115,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,644,200.00	55,115,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	725,645,866.89	1,062,320,210.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	725,645,866.89	1,062,320,210.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	724,432,112.28	1,062,317,464.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	498,146,310.64	745,464,350.00
210101	Үндсэн цалин	354,555,054.98	509,306,552.00
210102	Нэмэгдэл	127,480,153.66	216,501,858.00
210104	Урамшуулал	16,111,102.00	19,655,940.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,304,600.88	91,471,338.65
210201	Тэтгэврийн даатгал	42,137,431.88	63,068,945.65
210202	Тэтгэмжийн даатгал	4,980,362.00	7,230,037.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,935,000.00	3,619,619.00
210204	Ажилгүйдлийн даатгал	929,189.00	3,445,056.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,322,618.00	14,107,681.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,963,678.39	38,200,163.39
210301	Гэрэл, цахилгаан	3,173,508.39	5,045,363.39
210302	Түлш, халаалт	21,500,170.00	31,973,800.00
210303	Цэвэр, бохир ус	290,000.00	1,181,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,588,170.00	8,944,000.00
210402	Тээвэр, шатахуун	572,970.00	-
210408	Бараа материал акталсны зардал	1,015,200.00	8,944,000.00
2105	Нормативт зардал	83,195,610.00	99,857,620.00
210502	Хоол, хүнс	83,195,610.00	99,857,620.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,595,890.00	12,512,920.00
210604	Урсгал засвар	4,595,890.00	12,512,920.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	978,800.00	2,493,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	978,800.00	2,493,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,659,052.37	63,374,072.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,799,920.00	26,084,320.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,817,000.00	8,555,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,042,132.37	28,734,752.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,213,754.61	2,746.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	259,373.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	259,373.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,746.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,746.61
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	954,381.61	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	954,381.61	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	83,984,144.11	107,588,289.20
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	83,984,144.11	107,588,289.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	775,409,411.00	1,142,404,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,178,711.00	610,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,178,711.00	610,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	610,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	610,000.00
120009	Бусад орлого	1,178,711.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	773,230,700.00	1,141,794,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	743,586,500.00	1,086,679,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	743,586,500.00	1,086,679,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,644,200.00	55,115,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,644,200.00	55,115,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	694,891,326.52	1,032,573,577.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	694,891,326.52	1,032,573,577.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	693,677,571.91	1,032,570,830.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	497,944,652.64	745,131,868.88
210101	Үндсэн цалин	354,153,396.98	508,974,070.88
210102	Нэмэгдэл	127,680,153.66	216,501,858.00
210104	Урамшуулал	16,111,102.00	19,655,940.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,304,600.88	91,471,338.65
210201	Тэтгэврийн даатгал	42,137,431.88	63,068,945.65
210202	Тэтгэмжийн даатгал	4,980,362.00	7,230,037.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,935,000.00	3,619,619.00
210204	Ажилгүйдлийн даатгал	929,189.00	3,445,056.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,322,618.00	14,107,681.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,707,178.39	45,177,333.39

210301	Гэрэл, цахилгаан	3,173,508.39	5,045,363.39
210302	Түлш, халаалт	20,243,670.00	38,950,970.00
210303	Цэвэр, бохир ус	290,000.00	1,181,000.00
2105	Нормативт зардал	79,799,510.00	105,604,370.00
210502	Хоол, хүнс	79,799,510.00	105,604,370.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,982,640.00	9,934,920.00
210604	Урсгал засвар	4,982,640.00	9,934,920.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,381,700.00	3,061,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,381,700.00	3,061,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,557,290.00	32,189,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,624,990.00	23,299,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,932,300.00	8,890,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,213,754.61	2,746.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	259,373.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	259,373.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,746.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,746.61
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	954,381.61	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	954,381.61	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	80,518,084.48	109,830,522.47
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,560,900.00	5,089,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,560,900.00	5,089,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,560,900.00	5,089,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,560,900.00	5,089,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-4,560,900.00	-5,089,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	75,957,184.48	104,741,522.47
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,649,560.08	86,606,744.56
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	86,606,744.56	191,348,267.03

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	192,319,451.20	359,679,597.62
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	192,319,451.20	359,679,597.62
Тайлант үеийн үр дүн	-	-	83,984,144.11	83,984,144.11
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	276,303,595.31	443,663,741.73
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	276,303,595.31	443,663,741.73
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	276,303,595.31	443,663,741.73
Тайлант үеийн үр дүн	-	-	107,588,289.20	107,588,289.20
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	383,891,884.51	551,252,030.93

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,216,582,100.00	1,037,559,830.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,216,582,100.00	1,037,559,830.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,216,582,100.00	1,037,559,830.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	904,332,700.00	745,031,868.88
210101	Үндсэн цалин	632,587,300.00	508,874,070.88
210102	Нэмэгдэл	266,674,300.00	216,501,858.00
210104	Урамшуулал	5,071,100.00	19,655,940.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,820,000.00	91,471,338.65
210201	Тэтгэврийн даатгал	70,599,800.00	63,068,945.65
210202	Тэтгэмжийн даатгал	8,303,200.00	7,230,037.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,152,800.00	3,619,619.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,152,800.00	3,445,056.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,611,400.00	14,107,681.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,615,000.00	45,177,333.39
210301	Гэрэл, цахилгаан	6,750,000.00	5,045,363.39
210302	Түлш, халаалт	35,365,000.00	38,950,970.00
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	1,181,000.00
2105	Нормативт зардал	109,000,500.00	105,604,370.00
210502	Хоол, хүнс	109,000,500.00	105,604,370.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,934,920.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,934,920.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,061,600.00	3,061,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,061,600.00	3,061,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,752,300.00	37,278,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,861,900.00	28,388,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,890,400.00	8,890,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,216,072,100.00	1,141,791,353.39
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,216,072,100.00	1,141,791,353.39
122005	Орон нутгийн төсвөөс	1,142,294,100.00	1,141,791,353.39
132004	Оны эхний үлдэгдэлээс санхүүжих /орон нутаг/	73,778,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	86,606,744.56
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	191,348,267.03

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1.7 сая төгрөгийн албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлээ. Илрүүлсэн 1.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт

Нийт 2 албан хаагчид нийт 1,737.3 мянган төгрөгийн цалингийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг давхардуулан олгосон зөрчилтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлтийн 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах), 41 дүгээр зүйлийн 41.2.2 (батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах), 41.2 дахь хэсгийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6 (харьяа дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1 (Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно), 12.1.4 (хуулиар зөвшөөрөөгүй бусад), Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан (Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын хавсралт), 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан (Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх) журмыг тус тус зөрчсөн байна.

3.2 Зөвлөмж

1. Илрүүлэлт:

Хүнсний бараа, материалыг 99.8 сая төгрөгөөр худалдан авахдаа хууль тогтоомжийн дагуу тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 (Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна), 31.2. (харьцуулалт), 31.3 дахь (гэрээ шууд байгуулах) зүйл заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэл, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлж, тайлагнах хяналтыг сайжруулан, тендер шалгаруулалтыг хуульд заасан аргуудын хүрээнд зохион байгуулж, гэрээ байгуулах үйл явцыг ил тод, хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллах

2. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 52 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 (Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2 (Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна), үүнд 6.2.1 (Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон), “үнэлгээ ба хуваарилалт”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалтыг мөрдөж, Орон нутгийн өмчийн албанд асуудлыг шийдвэрлүүлэхээр хүргүүлэх.

3. Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээллийн 171 төрөлд хамрагдах 2 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.(тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх) заалтыг мөрдөж ажиллаагүй нь зүйд нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол, шуурхай байршуулж, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах дотоод хяналтын тогтолцоог сайжруулан, хариуцсан албан хаагчдын хяналт, хариуцлагыг өндөржүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Ур чадварын нэмэгдлийг 2 албан хаагчид давхардуулан олгосон	1	1,737.3			1	1,737.3		
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 52 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна	1						1	
Дүн	2	1,737.3			1	1,737.3	1	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
2 мэдээг хугацаанд нь байршуулаагүй	1				1	
Дүн	1				1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
99.8 сая төгрөгийн бараа материал тендер зарлалгүй шууд гэрээ хийн худалдан авсан	1				1	
Дүн	1				1	
Нийт дүн	2				2	